



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 13 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 13 дугаар хуралдаан 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдөр болов.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 13 дугаар хуралдаанаар /2025-06-16/ Тусгай зөвшөөрлийн тухай (Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Жимобайл ХХК-ийн дугаарлалтын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай; Бүртгэлийн гэрчилгээний хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт) зэрэг асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 11 (Тогтоол №128-138, 2025-06-16) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 13 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаар сунгах тухай үнэлгээ, дүгнэлт; Жимобайл ХХК-ийн дугаарлалтын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай; Бүртгэлийн гэрчилгээний хугацаа сунгах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлтийн болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 11 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 11 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 128 тоот тогтоолыг баталж, энэхүү тогтоолын хавсралтаар Юнивишн ХХК-д 21 аймгийн 304 сумын нутаг дэвсгэрт Утасгүй интернэтийн үйлчилгээнд “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” (Ашиглах давтамж: 5170-5210МГц, 5210-5250МГц, 5250-5290МГц, 5290-5330МГц, 5490-5530МГц, 5530-5570МГц, 5690-5730МГц, 5735-5775МГц, 5775-5815МГц) тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 129 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар (Гүнэс исиги ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс – БНХАУ/) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 130 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар

(Хэрлэн карго ХХК: “Дотоодын шуудангийн үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийг) шинээр олгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 131 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 6 хуулийн этгээдийн 6 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар (Монгол Улсын нутаг дэвсгэрт Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 132 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар (Шипт рүүт ХХК, 43200173 тоот: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс–АНУ/) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 133 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар (Цацраг трейд ХХК: Дорнод аймгийн Хэрлэн сумын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” (598-638МГц) 23410008 тоот тусгай зөвшөөрлийг”) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 134 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Юнител ХХК-ийн Монгол Улсын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” (1710-1715МГц, 1805-1810МГц, 1780-1785МГц, 1875-1880МГц) 24310008 тоот тусгай зөвшөөрлийг 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 2041 оны 06 дугаар сарын 26-ны өдөр хүртэл 16 жилийн хугацаагаар) сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 74 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 135 тоот “Жимобайл ХХК-ийн дугаарлалтын талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолыг баталсан. Тогтоолд,
 - Жимобайл ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын 9820xxxx-9879xxxx, 9320xxxx-9349xxxx багц бүхий нийт 900,000 /есөн зуун мянга/ дугаарыг буцаан авсугай.
 - Дугаарыг буцаан авсантай холбогдуулан хэрэглэгчдийг хохиролгүйгээр шилжүүлэх ажлыг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор багтаан зохион байгуулахыг Жимобайл ХХК-д үүрэг болгосугай.
 - Дугаар шилжүүлэхэд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Жимобайл ХХК-ийн хэрэглэгчид сонголт бий болгох хүсэлтийг үндэслэн 8700xxxx-8711xxxx

дугаарлалтын багц болох нийт 120,000 /нэг зуун хорин мянга/ дугаарыг Жимобайл ХХК-д олгосугай.

- Дугаарыг буцаан авсантай холбогдуулан нийт 900,000 /есөн зуун мянга/ дугаарт хамаарах дугаарлалтын зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тус компаниас хүсэлт ирүүлсэн хугацааг харгалзан 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон тооцсугай.
- Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Жимобайл ХХК-тай байгуулсан сүлжээний дугаарлалтын гэрээнд холбогдох өөрчлөлтийг тусган, гэрээг шинэчлэн байгуулахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д даалгасугай.
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 136 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 харилцаа холбооны сүлжээний (Хасбанк ХК: 1800-1888) дугаарын ашиглалтыг 2 жилийн хугацаатай сунгасан;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.9 дэх заалт, Оул телеком ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 137 тоот тогтоолоор Оул телеком ХХК-ийн “1900-1818” дугаарлалт бүхий 30010687 тоот тусгай дугаар ашиглах бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 12.3 дахь хэсэг, Домэйн нэрийг бүртгэх, ашиглах журмын 6.1.8 дахь заалтуудыг тус тус үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 138 тоот тогтоолоор Мэйжикнэт ХХК-ийн MN болон MON өргөтгөлтэй домэйн нэрийн гэрээт бүртгэгчийн 10050001 тоот бүртгэлийн гэрчилгээний хугацааг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 2026 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр хүртэл 2 жилийн хугацаатай сунгаж тус тус шийдвэрлэв.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг [энд дарж](#) үзнэ үү).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-06-23